

Дотоодын нийт бүтээгдэхүүн (Үйлдвэрлэлийн арга) хариуцсан мэргэжилтэн, Цэвээн Бадамцэцэг

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
3.1. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;							
1	Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана.	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан.	Монгол Улсын 2026 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулгад тусгах. /1 танилцуулга /	Монгол Улсын 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтаар 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан. Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоолол, төсөөллийг боловсруулж, ажилласан.	3-р сар, 4-р сар, 9-р сар, 10-р сар	100%

					Мөн "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийг боловсруулахад шаардлагатай тооцоо, төсөөллийг боловсруулж, шаардлагатай баримт бичгүүдэд тусгаж ажилласан. Хавсралт: 2 файл		
3.2. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл гаргах;							
2	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	-	Эдийн засгийн 2026 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1 танилцуулга/	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай дотоодын нийт бүтээгдэхүүн болон салбаруудын өнөөгийн нөхцөл байдал, төсөөллийг боловсруулж, тайлан, танилцуулга бэлтгэсэн. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулгад дотоодын нийт бүтээгдэхүүний 2024 оны урьдчилсан гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл болон 2026 оны төсөөллийг боловсруулж, тусгасан. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны	4-р сар, 5-р сар	100%

					төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан бөгөөд 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийн дэлгэрэнгүй танилцуулгад эдийн засгийн өсөлт 2025 онд 7.5 хувь, 2026 онд 6.0 хувь байхаар тусгасан. Хавсралт: 4 файл		
3	Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macroeconomic diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ.	Танилцуулгын тоо	Өмнөх онуудад эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, улирал бүр тайлан бэлтгэсэн.	2025 оны I, II улиралд дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн байна. /2 танилцуулга/	Макро эдийн засгийн 2024 оны 4-р улирлын тайланг бэлтгэж, удирдлагад танилцуулан, олон нийтэд түгээсэн. Уг тайланд үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн болон болон уул уурхай, тээвэр, цахилгаан, худалдаа, үйлчилгээний салбаруудын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж богино хугацааны төлөв байдлын талаар тайлбар бэлтгэн танилцуулгад тусгасан. Мөн Монгол, Францын хамтарсан Ураны төслийн хөрөнгө оруулалты гэрээ, санхүүгийн тооцоолол	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	100%

					болон эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар шигтгээ бэлтгэн, танилцуулгад оруулсан. Макро эдийн засгийн 2025 оны 1-р улирлын тайланг боловсруулж байна.		
3.3. Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох							
4	Монгол Улсын эдийн засагт тохиолдож болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгана.	Танилцуулгад туссан тоо	2024 онд батлагдсан бодлогын баримт бичигт эдийн засагт тохиолдолж болзошгүй эрсдэлийг тодорхойлж тусгасан.	Болзошгүй эрсдэлийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулгад тусгасан байна. /1 танилцуулга/	Макро эдийн засгийн тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоол болон "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль"-ийн дэлгэрэнгүй танилцуулгад тус тус тусгасан. Хавсралт: 2 файл	4-р сар, 10-р сар	100%
5	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр танилцуулга бэлтгэн, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.	Танилцуулгын тоо	2024 онд сар бүр танилцуулга бэлтгэсэн.	2024 оны 1-6 сард танилцуулга бэлтгэсэн байна./6 танилцуулга/	Макро эдийн засгийн 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 1, 2, 3, 4 дүгээр сарын танилцуулга мэдээг монгол болон англиа хэлээр цаг хугацаанд нь бэлтгэж, удирдлагуудад танилцуулан, олон нийтэд түгээсэн. Уг сарын танилцуулга мэдээнд дотоодын нийт бүтээгдэхүүн, аж үйлдвэр,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					үйлчилгээний салбарын танилцуулгыг бэлтгэж ажилласан. Хавсралт: 5 файл		
3.5. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх;							
6	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд дотоодын нийт бүтээгдэхүүн болон салбаруудын өнөөгийн нөхцөл байдал, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026-2028 оны төсөөллийг боловсруулж, танилцуулгад тусгасан. Мөн хуулийн төслийн тооцоололд шаардлагатай нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, бодит ДНБ-ий өсөлтийн хувь, төсвийн тусгай шаардлагад ашиглагдах уул уурхайн бус нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоолол, төсөөллийг боловсруулсан. "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай"	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар	100%

					хуулийн төслийг 2025.04.30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай" хууль 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан. Хавсралт: 2 файл		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдаж, ур	-	-	Өөрийн хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд холбогдох сургалт, семинарт тухай бүр хамрагдсан. Тухайлбал, ОУВС-ийн "Macroeconometric Forecasting" цахим сургалт, 2025.06.05-ны өдөр Үндэсний статистикийн хорооноос зохион	6-р сар, 12-р сар	100%

	хөгжүүлэх	чадвараа дээшлүүлсэн байх			байгуулсан "Дотоодын нийт бүтээгдэхүүн, хэрэглээний үнийн индекс болон үйлдвэрлэгчийн үнийн индексийг тооцох арга зүй"-г танилцуулах уулзалт, хуралд оролцсон. Мөн яам, газар, хэлтсээс зохион байгуулагдсан холбогдох сургалт, хөтөлбөрт тухай бүр хамрагдсан.		
2	Албан хаагчдад мэдээлэл түгээх, санал, солилцох зорилготой "Мэдээллийн цаг"-т оролцсон байна.	Яамны "Мэдээллийн цаг"-т оролцсон байх	-	Яамны "Мэдээллийн цаг"-т оролцсон байна.	"Олон ишт ба ёс зүйн эдийн засаг: Антропологийн чиг хандлага", "Ажил, амьдралын тэнцвэр" гэх мэт яамнаас зохион байгуулсан мэдээллийн цаг, дотоод сургалтад хамрагдсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Л.Энх-Амгалан

/...../

Огноо:



ТАЙЛАН ГАРГАСАН:

Дотоодын нийт бүтээгдэхүүн (Үйлдвэрлэлийн арга) хариуцсан мэргэжилтэн, Ц.Бадамцэцэг

/...../

Огноо: 2025.06.25